

Оюу Толгой миний нүдээр

*Монгол Улсын их сургуулийн харъяа
Улаанбаатар сургуулийн
Социологи-Нийгмийн ажилтны
4-р курсын оюутан Б.Буян-Эрдэнэ*

Төв азийн цээжинд орших, морин туурайгаар тамгалагдсан, хосгүй их баялгийг өвөртөлсөн, энэ газар нутгийн эзэд болсон Монгол хэмээх үндэстэн бид их хувь заяатай ард түмэн билээ. Тиймээс бид зовж, зүдэрч ядуу тарчиг амьдрах эрх бидэнд үгүй. Монголын баялгийг ард түмэнд хүргэж байгаа гол хүчин бол Оюу Толгой компани гэж би боддог. Хэрэв энэ компани байхгүй байсан бол өнөөдөр бид алтан дээр суусан гуйлгачид гэсэн нэрийг өнө мөнхөд сонсох байсан биз.

Монгол Улс, Монгол хүний хөгжлийн гол хэрэглүүр болох эдийн засгийн хөдөлгөгч хүч нь Оюу Толгой компанийн хөрөнгө дээр суурьлагдаж, жилээс жилд өссөөр 2013 оны байдлаар нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүн 4,934.4 мянган төгрөгт хүрсэн байна. Оюу Толгой компани зөвхөн эдийн засагт төдийгүй ажиллах хүчний их нөөцийг бүрдүүлсэн, их бүтээн байгуулалт, орон нутгийн хөгжилд жинтэй хувь нэмэр оруулж байна. Энэ байгууллагад 8,000 монгол хүмүүсийн амьдралын утга учир, гол эх үүсвэр, ажлын байрыг бий болгож байна. Хэрэв Оюу Толгой зогсвол 8,000 ажилчид, тэдний ар гэрийнхэн, үр хүүхдээ сайн ажил хийж яваа гэсэн эцэг эхийн сэтгэл яах вэ? Төр эдгээр хүмүүсийг ажлын байраар хангаж чадах уу? үгүй юу? гэсэн асуулт нь Оюу Толгойг Монголын ард түмэнд ийм л их хувь нэмэр оруулж байгааг харуулж байна.

Би Оюу Толгой компанид очиж үзээгүй ч гэсэн миний төсөөлж, бодсноор тэнд ажиллахыг хүссэн олон мянган хүний хүсэл эрмэлзлэл байдгийг би мэднэ. Намайг 11-р ангиа төгсөх жил манай үеийнхний мөрөөдөл бол уул уурхайн чиглэлийн мэргэжилтэн болох байлаа. Яагаад гэвэл төгсөөд Оюу Толгой компанид ажилд орох, энэ компанид ажилд орвол өндөр цалин авна, ажлын хангамж сайтай гээд тэнд ажилладаг хүмүүсээс их сонсож байсан болохоор бидний мөрөөдөл Оюу Толгой хэмээх тэр их нэр хүндтэй байгууллагад орох байсан юм. Гэвч би уул уурхайн чиглэлийн мэргэжилтэн болж чадаагүй л дээ.

Манай төрлийн нэг ах их сургуулиа төгсөөд Оюу Толгойд ажилд ороход, том байгууллагад орсон гээд манай хамаатнууд бөөн баяр болж байсан. Одоо тэр ах маань тушаал дэвшээд, эхнэр хүүхдийн хамт их сайхан амьдарч байна. Оюу Толгой бол бидний хувьд ийм л хүсэл сэтгэлийг шингээсэн байдаг. Хүн үргэлж сайн сайхан зүйл рүү хүсч тэмүүлж байдаг. Оюу Толгойд ажиллах гэсэн олон хүмүүсийн хүслийг юу их татдаг юм бол? Магадгүй бусад байгууллагуудыг бодвол ажилчиддаа өсч дэвжих, сайхан амьдрах боломжийг бүрдүүлдэг байж болох юм. Бусад байгууллагыг бодвол гэр орноосоо хол ажилладаг гэсэн ч тэр хүмүүсийн сэтгэлийг татаж, ажиллах нөхцлийг бүрдүүлж, эрүүл мэндийг нь хамгаалж ажиллуулж чадаж байгаа нь өөрөө гайхамшиг юм.

Монголын баялаг болсон оюутан залууст оюуны их үйлсэд нь жинтэй хувь нэмэр оруулж байгаад Оюу Толгойн хамт олон та бүхэнд баярлаж байгаагаа хэлэхэд таатай байна. Хүнд эд материалын дэмжлэг гэхээс илүү оюунд нь хөрөнгө оруулалт хийж байгаа нь жинхэнэ насан туршийн хөрөнгө оруулалт болж байгаа юм. Танай тэтгэлэг оюутан бидэнд цаашдаа хичээж,

чармайж сурах их эрмэлзлэл өгдөг. Гэвч би жил бүр танай тэтгэлэгт хөтөлбөрт орохыг хүсдэг боловч мэргэжил заасан байдаг болохоор орж чаддаггүйд их харамсдаг.

Танай компани ирээдүйн Монголын хөгжил цэцэглэлтэд их хувь нэмэр оруулна гэдэгт би итгэж байна, миний зүрхэнд итгэлийн гэрэл асч байна.